



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 378

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 6,885,220.00 (зургаан сая найман зуун наян таван мянга хоёр зуун хорин) төгрөгийн балансын үнэ, 1,320,681.60 (нэг сая гурван зуун хорин мянга зургаан зуун наян нэгэн төгрөг жаран мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Л.Дашдэмбэрэлд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Акталж байгаа төмөр хашааг “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” төрийн өмчит хувьцаат компанид тушаах;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАНБОЛД

132005712  
19-r\_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 07 дугаар сарын 07-ний өдрийн  
3.7.2 дугаар тогтоолын хавсралт



Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын  
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй актлах  
хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ, (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг үнэ (төгрөг)
1	Төмөр хашаа	2008	3,768,610.00	628,101.60	3,140,508.40
2	Явган хүний зам	2008	3,116,610.00	692,580.00	2,424,030.00
	Нийт дүн		<b>6,885,220.00</b> (зургаан сая найман зуун наян таван мянга хоёр зуун хорин)	<b>1,320,681.60</b> (нэг сая гурван зуун хорин мянга зургаан зуун наян нэгэн төгрөг жаран мөнгө)	<b>5,564,538.40</b> (таван сая таван зуун жаран дөрвөн мянга таван зуун гучин найман төгрөг дөчин мөнгө)